

<p>4.9.2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын үйл ажиллагааг сайжруулж, болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлнэ.</p>	<p>2</p>	<p>Эрсдэлээс урьдчилан сэргийлэх хамгаалах, сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулах</p>	<p>2024-2028</p>	<p>Орон нутгийн төсөв</p>	<p>Хамрагдсан хүний тоо</p>	<p>287</p>	<p>267</p>	<p>9.5</p>	<p>Аймгийн бүх сумдын ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга, Засаг дарга, ЗДТГ-ын дарга, Санхүүгийн албаны дарга, мэргэжилтэн, нягтлан бодогч, ойн анги, орон нутгийн төсөвт байгууллага болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дарга, санхүүч нарыг хамруулан "Төсөв захирагч, санхүү бүртгэлийн ажилтнуудын нэгдсэн сургалт, зөвлөгөөн"-ийг зохион байгуулж, ДОТООД АУДИТЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАХ АРГА ЗҮЙН ЗӨВЛӨМЖ гэсэн сэдвүүдээр илтгэл тавьсан.</p> <p>- Жаргалант, Хотонт сумын төсөвт албан байгууллагуудын ажилтан албан хаагчдад ДОТООД АУДИТЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ЭРСДЭЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ зэрэг сэдвүүдээр мэдээлэл өгч, гарын авлага бэлтгэн тараасан.</p> <p>-Эрдэнэбулган сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургууль, Ирээдүй бага сургууль-цэцэрлэгийн цогцолбор, Хүүхдийн 2, 5, 8, 4, 11, 14, 15 дүгээр цэцэрлэгийн захирал, эрхлэгч, дотоод хяналтын багийн гишүүд, эрсдэл хариуцсан ажилтнуудад байгууллагын засаглал, эрсдэл, дотоод хяналтын үйл ажиллагааг сайжруулах зөвлөмж чиглэл өгч ажиллалаа. Мөн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан эрсдэлийг хэрхэн тодорхойлох, үнэлгээ хийх чиглэл, эрсдэлд суурилан дотоод хяналтыг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах, үр дүнг тооцох, эрсдэлийг бууруулах талаар зөвлөмж өгсөн. "Эрсдэл" гэсэн таниулах хуудас бэлтгэж, зөвлөгөө мэдээлэл авахаар ирсэн байгууллагуудад өгсөн.</p> <p>- Аудит, хяналт шалгалтад хамрагдсан нийт 46 байгууллагын 92 төсөв захирагч, санхүүгийн ажилтнуудад хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэхэд анхаарах асуудлаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа. Байгууллагын цахим хуудсаар зөвлөгөө мэдээллийг тухай бүр олон нийтэд хүргэлээ.</p>
100%									

	3	Төсвийг зориулалтын дагуу зарцуулсан эсэхэд тавихад сэдэвчилсэн хяналтыг зохион байгуулж, үр нөлөөг сайжруулах	2024-2028	Орон нутгийн төсөв	хяналт шалгалтын тоо	22	25	Аймгийн боловсролын салбарт төсвийг зориулалтын дагуу зарцуулсан эсэхэд сэдэвчилсэн хяналт шалгалт хийхэд аймгийн Боловсролын газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн б/108 дугаар тушаалаар 2023 оны санхүүгийн тайлан улсын хэмжээнд гарсантай холбоотойгоор санхүүгийн тайлангийн нэгтгэлд "Өөрчлөлтгүй", Итгэл үзүүлсэн", Түүвэрт" хамрагдсан гэж дүгнэгдсэн 13 сургуулийн захиралд 20.1 сая төгрөг, 19 хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч нарт 29.3 сая төгрөг, нийт 49.4 сая төгрөгийн балансын урамшууллыг цалингийн сангаас олгож, зориулалт бусаар зарцуулсныг аймгийн төсвийн орлогод нөхөн төлүүлэхээр акт тогтоолоо.	100%
	4	Аудит, хяналт шалгалтаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнг үнэлэх	2024-2028	Орон нутгийн төсөв	Зөвлөмжийн биелэлтийн хувь	80	85	Архангай аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн Дотоод аудитын хорооны зөвлөмж-3, Дотоод аудиторын зөвлөмж-25, хяналт шалгалтын танилцуулгаар өгсөн зөвлөмж-10 нийтдээ 28 зөвлөмжийг сумд, агентлаг, байгууллагуудад өгсөн.	92%

ТАЙЛАН ГАРГАСАН:

АХЛАХ ДОТООД АУДИТОР

А.БУЯНДЭЛГЭР

ХЯНАСАН:

ДАРГА

Д.ГАНДОЛГОР